

**“ХҮҮХДИЙН АЯЛГУУТ АМАН ЗОХИОЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛС  
АРДЫН УРЛАГИЙН ҮНДЭС БОЛОХ НЬ”**

**Л. Хэрлэн \***

Аман зохиолын судлагааны аялгуулах аман зохиолын зүйлд ерөөл, магтаал, тууль, ардын дуу зэргийг голлон авч судалсан байдаг. Эндээс бүүвэйн дууг эс тооцвол хүүхдийн аман зохиолд холбогдох бусад төрөл зүйлсийг хамруулж үзээгүй байна.

Аман зохиолд амаар аялгуулан аялах, шүлэглэх олон хэлбэрүүд бий. Жишээлбэл: Даалуу, Дулдуй (шашин), Дайралцаа, Хуа, Дэмбээ, Сампингийн ая аялгуу, Зарын ая аялгуу (богд хааны зарлиг унших), Худалдаа, Явган үлгэрийн ая, Захиа дуудах, Тасха авах, Хул, Цагаан лонх, Тунгаах ая юм.

Хүүхдийн аман зохиолын тоглоомын аялгуут бус аман зохиолд оньсого, зүйр, цэцэн үг, ертөнцийн гурав, жороо үг, түргэн хэллэг зэрэг тоглоом наадмын үгс болон ардын тоглоомын хөдөлгөөнт, хөлөгт, үгэн төрөл зүйлсүүдийг хамруулан үзэж байна.

Хүүхдийн аман зохиолын тоглоомын аялгуут аман зохиолд бүүвэйн дуу, дайралцаан, оньсого худалдах үг, 64 хул, 32 цагаан лонх /гийнгоо, уухай, марзай/ зэргийг хамруулж болно.

Хүүхдийн аман зохиолын хамгийн гол онцлог бол тоглоом наадмын адилаар хүүхэд багачуудын зугаацал сонирхолыг татаж, тэдний танин мэдэхүйн хөгжилд их ач холбогдолтой юм. Хүүхдийн аман зохиолын хүрээнд багтдаг бүүвэйн дуу, хэл зүгшрүүлэх үг, зугаа үг, үлгэр, оньсого тэргүүтэн нь хүүхдийг зугаацуулахаас гадна, тэдний амьдралд гүн нэвтрэн оюун сэтгэхүйд нөлөөлдөг.

Дорно дахины арга билэгийн ёсоор аав бол гал, ээж бол ус тиймээс хүүхэд аавдаа хэт ойртвол шатна, ээждээ хэт ойртвол живнэ. Тиймээс хүүхэд энэ хоёрын дундаж барьж хүмүүжих ёстой бөгөөд аль алинд нь хэт эрх өсвөл санаж сэдэхээр дутмаг, хэл дультраа (хэлгий), ажил анхи муутай, эрхийн тэнэг болно гэж сэрэмжилдэг. Хэлд ороогүй хүүхдэд эгшиг авиа дуудуулж, авиаг амилуулж үг хэл хэлүүлж сургана. Ингээд хүүхдэд элдэв юмыг тоочин сургахын тулд үгийн хэлбэр, айзамд тааруулан тоочин сургахдаа бад бааран, бадам хоорон, оо тоорон, отгоч мээрэн, онч бүүвэй гэх мэтээр хурууны тоёлогын эцэст чигчийг нь имрэн инээлгэх, хуруу таалгах, үг хэлээд, юм цээжлээд ирэхийн үед амьсгал зөв авах, хувиарлах чадвар эзэмшүүлэхийн тулд “гучин хоёр цагаан лонх”, “жаран дөрвөн хул” нэг амьсгаагаар тоолуулдаг нь айзам, хэмнэл тааруулж сурах үндэс болдог. Ингэж авиа, үгийг зөв хэмнэлээр дуудаж сурсны дараа хэл ярианы эрхтэнг идэвхжүүлэх “жороо үг”, “зугаа үг” хэлүүлдэг. Ийнхүү хэлний

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Урлаг судлалын тэнхим



хэллэгийг зөв дуудуулж сургах, өгүүлэх болон амьсгалын эрхтний ажиллагааг засч зүгшрүүлэх, зугаацан наадах, хэл ярианы хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг үгийн урлагийн онцгой хэлбэр гэж үзээд хүүхдэд багаас нь эзэмшүүлж ирсэн бөгөөд оюун ухаан, ёс суртахуун, танин мэдэхүйн ач холбогдолтой хэлбэр мөн.

Энэхүү монгол түмний түргэн хэллэг, жороо үг нь эгшиг авиаг бүтээх явцад авиан хуваарилалтыг зохицуулах, үг хэллэгийг зүгшрүүлэх, хэл зөөллөх дасгал сургуулилтанд бас нэг үндсэн дэг болдог. Жишээлбэл:

1. *Хүрэл илүүр, болор соруул, (давтан хэлэх)*
2. *Ээжийн илүүр, хайруул бариул гурав*  
*Эгчийн ээрүүл, хайлуур, баллуур гурав*
3. *Арван таван тарган тарлан*  
*Хар сарлангийн таргийг*  
*Тараг биш гэж эс уугаад*  
*Ямар арван таван тарган тарлан*  
*Хар сарлагийн таргийг*  
*Тараг мөн гэж уух вэ?*
4. *Нар холуур хүрээлэв үү*  
*Ойроор хүрээлэв үү*  
*Сар сая хүрээлэв үү*  
*Сүүлд хүрээлэв үү?*
4. *Алаг бяруу араараа эргээд*  
*Араа ч долооно, далаа ч долооно*  
*Далнгаа ч долооно*  
*Дэлэнгээ ч долооно*

гэх зэргээр монгол ардын түргэн хэллэг, жороо үгсийг өнөөгийн хөгжмийн дасгал сургуулилтад зайлшгүй хийдэг дасгал бөгөөд энэ нь хэлийг уян хатан болгох эгшиг авиаг зөв эгшиглүүлэхэд чухал үүрэгтэй үндсэн сургуулилт юм. Энэ утгаараа түргэн хэллэг, жороо үг нь жүжгийн болон дуу хөгжмийн сургалтанд суралцагсдын хэл хэллэгт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Хүүхдийн аман зохиол дахь **түргэн хэллэг** нь ая аялгуугүй ч гэсэн нэг хэмнэлд үгийг зөв хуваарилах, хэл хэллэгийг түгдрэлгүй зөв тод дуудах нэгэн дасгал сургууль юм. Жишээлбэл:

- Ээжийн илүүр, хайруул бариул гурав*  
*Эгчийн ээрүүл, хайлуур, баллуур гурав*

Энд байгаа 2 мөртөд 3-4 үг давтагдан хэлэгдэх бөгөөд үгийн эхний мөртөд хүчтэй хувийг хуваарилаж дуудна. Гэтэл монгол хэлний тод дуудагдах “л”, “р” үгүүд сул хувьд ноогдож хэм хэмнэлийг сулруулж дуудагдахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл “л” үсэг хэлний үзүүрээр нэг удаа шүргэгдэх зөөлөн байдлаар хэлэгддэг бол “р” үсэг хэлний үзүүрээр давтсан байдлаар чанга дуудагдах тэр хэмнэл эсрэгээр сул хувьд ноогдсоноор энэ хоёр гийгүүлэгч солгидон хэлэгдэх байдал ажиглагддаг байна. Тиймээс түргэн хэллэгийг утга санааг нь эхлэж ойлгоод дараа нь хэлний хувиарлалтандаа зөв түргэн хэлэхэд анхаарлаа төвлөрүүлэн дуудаж сурахад гол зорилго нь оршдог.

Ийнхүү амьсгал тогтоох, түргэн хэллэгүүдээс гадна эгшиг авиад суралцах, хэмнэл, ая аялгууг сонсох, тогтоох арга ухааныг ч бас давхар олгож байсан жишээ бол гийнгоо юм.

**Гийнгоо.** Мал аж ахуйтай холбоотой ая, аялгууны нэгэн хэсэг нь гийнгоо юм. Урлаг судлаач Ж.Бадраа гуай “Гийнгоо гэж хурдан морины уралдааны ая нь үүсэл гарвалын хувьд нэн эрт үед хамаарагдах бөгөөд хүч зорир, хүсэл зорилгыг хуралдуулах гэсэн хийсвэр утга агуулгатайн дээр нэгэн зүйлийн уухай ая юм... гээд үүнийгээ “зээ уухай” гэдэг үгнээс гаралтай байж болно, үүнд: “жээ хухай”, “жээхө”, “жэбуо”, “жээгуо”, “жээнгоо”, “гийнгоо” гэсэн авианы хувилбар сэлгэцээр өөрчлөгдсөн байж болно гэж үзсэн байдаг.<sup>3</sup>

“Хухай буюу хурай” гэдэг шалмаг түргэн хөдлөх, хурахын утга санаатай тул “хурдан давхих болтугай” гэсэн бэлгэдлийн үг болгон хурдан морины уралдааны зан үйлд хэрэглэсэн байж болох талтай.



Гийнгоон ая хэрхэн үүссэн тухай нэгэн домогт: Эрт цагт Гийн гэдэг ядуу хүү хааны наадамд Гоо гэдэг даагаа уралдуулах гэхэд хаад баячууд түүнийг гадуурхан наадамд оролцуулахгүй гэж хориглоход хүү “гийнгоо” хэмээн яруу сайхнаар уянгалуулан аялсанд наадамчид уярч хүүг наадамд оролцуулахаар болсон. Түүнээс хойш наадмын хурдан морины хүүхэд “гийнгоо” аялах болсон гэдэг домог байдаг ажээ.<sup>4</sup>

Үүнээс үзэхэд гийнгоон ая үүссэн учир шалтгаан нь мэдээжээр хурдан морины уралдаантай холбоотой ба хүн зоны, хүлэг мориныхоо сэтгэл, урмыг сэргээн хөгжөөх, хөхүүлэн дэмжих зорилготой байжээ. Морин уралдааны үүсэл нь маш эртний, чухамдаа гурав гэсэн тоог анхдагч “жинхэнэ” тоо гэж үзэж ойлгож байсан тэр үетэй холбогдох бололтой. Монголчууд эрт үед морь тавих ба утгахад дуу дуулж, хөгжим үүсгэж байсныг мэдэж болно. Энэ нь зүйрлүүлж хэлбэл шагайн уухайтай адил юм.

Шарын шашин Монголд хүчтэй дэлгэрсэн үед наадмын зан үйлд шашны нөлөө орж гийнгоон аянд тарнийн үгс орж иржээ. Энэ үеэс гийнгоон аяыг “Марзай” хэмээгээд гийнгоолохыг марзай татах, марзайлах гэх болжээ. Марзай гэдэг нь бурханы тарни бөгөөд ус, гал, салхи, арслан, зэр зэвэг, хулгай дээрэм, хэл ам, хэрүүл гэх мэтийн найман аюулаас аварч зайлуулах шидтэй тул уралдааны замд тохиолдож болзошгүй аюул ослыг зайлуулж, эсэн мэнд, сайхан уралдаж ирэх, нөгөө талаас уралдах гэж буй морины цог хийморийг сэргээн урамшуулах гэсэн давхар давхар үүрэг, утгатай боловч хүүхдэд нөлөөлөх гол зүйл нь гийнгоогоо аялгуулан дуулах явцад хүүхдийн хоолой нь задарч, цараа хүрээ, хоолойн чадал нь нэмэгдэх, зан заншлаа мэдэх уламжлах, унасан морио баясгаж дуу хоолой, сэтгэл бүхнээрээ холбогдож байгаад оршиж байна.

Хүүхдийн аман зохиолд гийнгоог хамааруулан үздэггүй тал бий. Энэ нь дан аялгуу байх бөгөөд шүлэглэсэн зохиомж байдаггүйтэй холбоотой. Гэхдээ хүүхдийн аялгуут

<sup>3</sup>) Ж.Бадраа, “Монгол ардын хөгжим”, УБ., 1999

<sup>4</sup>) С.Жамбалдорж, “Морин эрдэнэ”, УБ., 1996

аман хэлбэрт гийнгоо яах аргагүй багтана. Гийнгоо нь хүүхдэд аялгууг тогтоох, хоолойн чадамж, царааг өргөсгөх гол дасгал сургуулилт болно. Дайралцаа шиг оюун ухааныг сорих, хэм хэмнэл аялгууны хувиарлалтаас гийнгоо нь аялгууны цараа, чимэглэл, уртын дууны эгшиг томолтын зарим элемент энд ажиглагддаг. Жишээлбэл:

“Зээ” гэсэн ганц энэ үгэнд

*Дунд зэрэг*



Зээ


Хоолойн чимэглэл триоль хоёр удаа, прошлаг хоёр удаа байх бөгөөд нэг өнгөн дээр барисан хоолойн өнгийг тогтоосон байдал ажиглагдаж байна. Цааш нь “гийнгоо” гэсэн үгэнд



аялгуулан дуулагдах байдал нь чөлөөтэй нэг өнгөнөөс нөгөө өнгөнд зөөлөн шилжсэн байдалтай, нэг эгшиг дээр олон удаа хоолойн цохилго



хийгдэж байна. Мөн нэг эгшгээс нөгөө эгшигрүү шилжих хөдөлгөөн нь нэг бол унасан эсвэл дээш эгшиг дараалан өгссөн




байдалтай дуулагддаг. Гийнгооны дуулагдах цараа нь ганцхан наймц дотор дээд өнгөнд хүүхдийн цангинсан хоолойгоор дуулагддаг байгаа нь хоолойн чадамжийг илтгэх байдалтай байна. Гийнгоо нь морь, бөх, сур, шагайн уухайн нэгэн адил хөг эгшиглэгээ, хоолойн чадамжийг илтгэх нэгэн өвөрмөц аман аялгуу бололтой. Тийм ч учраас эдгээр сул аялгуу нь уртын дууны, ер нь дууны урлагийн дасгал сургуулилтын уг үндэс нь болж өнөө ч сургалтанд уламжлагджээ.

Монголчууд “найранд гурван дуутай, наадамд гурван даваатай” байдаг нь багаасаа хурдан морь унаж, гийнгоо аялж, сур шагайн уухай уухайлж өссөнтэй холбоотой нь илэрхий.

Ийнхүү зөв сонголонг хоолойн чадамж, хөг хэмнэлийг эзэмших явцдаа анхаарал ой санамж, элдэв үйл явдлыг дүрслэх арга ухааныг ч сурч эзэмшиж байв. Хүүхдийн аялгуут аман зохиолууд нь хүүхдийн хоолойд тохирсон аялгууны элдэв үсрэлт, чимэглэл багатай, энгийн бөгөөд аялгуулаг шинжтэй байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь: **Дайралцааны аялгуу** нь хоёр наймцын цараанд дуулагдаж байгаа нь хүүхдийн хоолойн онцлогт тохирсон дуулагдах хоолойн цар хүрээ юм. Эхлэхдээ:

*Зээ хүү минь үнэхээр тийм үү дээ*

*Дунд зэрэг*




Зээ хүү ми - нь үнэ - хээ - р тий - мүү дээ

гэдэг угтвар аялгуу нь анхаарал төвлөрүүлэх дараагийн шүлэг ая аялгууны бэлтгэл болдог. Энд хоёрдугаар наймцын ля нотноос нэгдүгээр наймцын ля хүртэл нэг наймцын дотор аялгуу уруудах байдлаар доошилж сүүлийн нотон дээрээ тогтож байна.

Дайралцаан эхлэхдээ:

*Зурман тааны нүхэнд нь*

*Зургаан салаа байна уу даа*



Зур - ман таа - ны нү - хэнд нь Зур - гаан сала - аа байна уу даа

гэсэн асуух шүлгийн мөртүүдийн аялгуу нь эхлээд шинэ санаа эхлэж байгаа учраас аялгууны эгшиглэгээ ч шинэ нотноос эхлэж байна. Жишээ нь хоёрдугаар наймцын ми нотноос дээш цэвэр квартын зайнд нэг эгшигийг 1-3 удаа давтсан байдалтай байгаа нь уг шүлэглэлийнхээ утга санааг тодотгох, сануулах, асуух байдлыг илэрхийлж байна. Нэг эгшиглэг дээр хэд хэдэн удаа давтагдах үг нь нэг жигд хэмнэлээр хэлэгдэх нь тухайн үгийг тодотгох санаа бөгөөд түүнийгээ нэг эгшигээр тодотгон аялгуулж байгаа байдал ажиглагдаж байна. Цааш нь:

*Зулган чиний цээжинд*

*Зургаан шүлэг байна уу даа*



Зул - ган чи - ний цээ - жинд нь Зур - гаан шү - лэг байна уу даа

Энд мөн л шинэ утга санааг эхлэхдээ шинэ эгшиглэгээнээс эхлэж мөн л нэг наймцын дотор 1-3 эгшигийн давталттай тэгш хэмжээгээр давтагдаж харин эхэлсэн өнгөндөө дуусч байгаа нь тухайн шүлгийн утга санааг бататгах шинжтэй. Энэ аялгуу цааш нөгөө хүнд давтагдан дуулагдах бөгөөд харин шүлгийн хувьд тухайн хүүхдийн шүлгийн зохиомжийг сорих байдлаар үргэлжилдэг. Ая аялгууны хувьд нутаг нутагт янз бүрийн аялгуугаар дуулагдаж уг аялгуу нь нийлэг тархсан аялгуу юм. Магадгүй өөр өөр аялгуугаар дуулж талцан дайралцахад шүлгийн зохиомжиндоо анхаарал алдах, шүлгийн хэмнэл алдагдах байдал бий болох тул анхаарал сарних байдал гарах талтай. Тиймээс нэг аялгуунд дайралцааныг ихэвчлэн хийдэг байна.

Монгол аман зохиолын болон аман аялгууны эдгээр хэлбэрүүд нь монгол түмнийг дуучин, хуурчин болгох эх үндэс нь болоод зогсохгүй тэдгээрийг хүүхдэд бага наснаас нь эзэмшүүлэх дасгах, сургах арга ухааны нэг байсан бололтой. Энэ ч үүднээс монгол түмэний “найранд гурван дуутай, наадамд гурван даваатай” гэдэг үг огт хоосон биш төдийгүй дэлхийд гайхагдах урт аялгуут, хоолойн чадамж, эгшиглэгээний сонин гайхамшигт “уртын дуу”-ны үүсэл хөгжил нь монголчуудын зан үйл, хүүхдийн сурган хүмүүжүүлэх арга ухаанд хадгалагдан үлджээ гэж үзэж болно.

### **SUMMARY**

Genres of Mongolian folklore and oral melody were not only foundations for singers and storytellers; they were also teaching methods and clever ways to train children. Genres of children's folklore are basics of folk art. The origin and development of magnificent Mongolian long songs are a near perfect glimpse of the teaching methods and rituals of Mongolians.